

**“МАЛЫН ЭМИЙН ҮЛДЭГДЛИЙН ХЯНАЛТ”-ЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2020 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)	ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” А-178 дугаар тушаалаар “Малын эмийн үлдэгдлийн хяналт”-ын үндэсний хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний баталсан. Хөтөлбөрийн зорилго: Улсын хэмжээнд малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, баталгаатай эмээр хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн үлдэгдлийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх замаар хүн, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангах, худалдааны чөлөөт байдлыг дэмжиж олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийг хангахад чиглэсэн тогтолцоог бий болгоход оршино.			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ: 6.1.1. улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт; 6.1.2. төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж ; 6.1.3. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ, Мал эмнэлгийн ерөнхий газар, 4 жил - 2019-2023 он Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, харьяа мэргэжлийн байгууллага			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 2.2.1: Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлт, пестицидийн үлдэгдэл, малын эмийн бүртгэл, сорилт баталгаажуулалт, дотоод, гадаад худалдааны хяналт, түгээлт, хадгалалт, хэрэглээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох; Зорилт 2.2.2: Малын эмийн үйлдвэр, худалдаа, судалгаа, шинжилгээний чиглэлийн мэргэшсэн, ур чадвар бүхий хүний нөөцөөр хангах; Зорилт 2.2.3: Малын эмийн сорилт, баталгаажуулалт, мал, амьтны эм, тэжээлийн нэмэлт, пестицидийн үлдэгдлийг хянах судалгаа, шинжилгээний лабораторийн чадавхыг сайжруулах, итгэмжлэлийн хүрээг өргөжүүлэн итгэмжлэлд хамруулах; Зорилт 2.2.4: Эмийн зохистой хэрэглээ, хүртээмж, хангамж, эмийн чанар аюулгүй байдлын баталгааг хангах; Зорилт 2.2.5: Мал, амьтны эмийн нэгдсэн мэдээллийн сүлжээг бий болгож, олон нийтэд мэдээллийн нээлттэй орчинг бүрдүүлэх;			
5	Зардал	Төсөв (Нийт зардал)	Зардал төсөвлөөгүй		
		Үүнд:	Төсөв (2020 он)	Гүйцэтгэл	Хувь
		Нийт			
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ			
	1-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 7-11 дугаар хуудас.			
	2-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 11-18 дүгээр хуудас.			
	3-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 18-20 дугаар хуудас.			

	4-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 21-23 дугаар хуудас.						
	5-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 24 дүгээр хуудас.						
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Дүгнэлт.</p> <ol style="list-style-type: none"> Хөтөлбөрийн төлөвлөгөөний 5 зорилтын хүрээнд 61 арга хэмжээ хэрэгжүүлснээс 2020 хэрэгжилтийн дундаж оны үнэлгээ 72.0 хувьтай байна. Тус хөтөлбөрт 2019 онд жилийн турш хэрэгжээгүй гэж үзэж хяналт-шинжилгээ хийсэн тул 2020 онд 2019 болон 2020 оны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Тус хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан баримт бичиг боловсруулах, батлуулахаар тусгагдсан эрх зүйн болон бусад зохицуулалтын шинж чанартай арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 69.7, сургалтын арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 70.0, гарын авлага бэлтгэх, түгээх арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 75.0, санхүүжилт нэн шаардлагатай 10 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 77.8 хувиар тус тус дүгнэгдэж байна. Хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан зардлыг тайлагнаагүй тул үнэлгээнд харгалзаж үзэх боломжгүй байв. <p>Зөвлөмж.</p> <ol style="list-style-type: none"> Тус хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхдээ удирдлага зохион байгуулалтыг сайжруулж, нэн шаардлагатай арга хэмжээнд шаардагдах төсвийг улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх замаар хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газарт зөвлөж байна. 						
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Тодорхой үр дүнд хүрсэн						
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ) Төсөл хэрэгжиж эхэлснээс хойших үнэлгээгээр	Биелэлт дундаж	Зорилт тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		72.0	5	72.5	72.1	63.3	62.10	90.0
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ						
		... %						

ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА.

ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” А-178 дугаар тушаалаар “Малын эмийн үлдэгдлийн хяналт”-ын үндэсний хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталсан

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.

Арга хэмжээний гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан тогтоож, тэдгээрийн хоорондын зөрүүг илрүүлэн дүн шинжилгээ хийж шалтгааныг тодруулах, түүнд үндэслэн зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2020 оны жилийн эцсийн тайланг судлах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтантай ярилцах, холбогдох газраас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

Хөтөлбөрийн зорилго. Улсын хэмжээнд малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, баталгаатай эмээр хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн үлдэгдлийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх замаар хүн, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангах, худалдааны чөлөөт байдлыг дэмжиж олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийг хангахад чиглэсэн тогтолцоог бий болгоход оршино.

Хөтөлбөрийн зорилт.

2.2.1: Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлт, пестицидийн үлдэгдэл, малын эмийн бүртгэл, сорилт баталгаажуулалт, дотоод, гадаад худалдааны хяналт, түгээлт, хадгалалт, хэрэглээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

2.2.2: Малын эмийн үйлдвэр, худалдаа, судалгаа, шинжилгээний чиглэлийн мэргэшсэн, ур чадвар бүхий хүний нөөцөөр хангах;

2.2.3: Малын эмийн сорилт, баталгаажуулалт, мал, амьтны эм, тэжээлийн нэмэлт, пестицидийн үлдэгдлийг хянах судалгаа, шинжилгээний лабораторийн чадавхыг сайжруулах, итгэмжлэлийн хүрээг өргөжүүлэн итгэмжлэлд хамруулах;

2.2.4: Эмийн зохистой хэрэглээ, хүртээмж, хангамж, эмийн чанар аюулгүй байдлын баталгааг хангах;

2.2.5: Мал, амьтны эмийн нэгдсэн мэдээллийн сүлжээг бий болгож, олон нийтэд мэдээллийн нээлттэй орчинг бүрдүүлэх.

Хүлээгдэж буй үр дүн

1. Эмийн бүртгэл, чанарын хяналт, эм үйлдвэрлэлийн зохистой дадлыг бэхжүүлж, хэрэглэгчийг эмчилгээний идэвхитэй, чанартай, аюулгүй эмээр хангах эрх зүйн орчин бүрдэнэ.
2. Мал эмнэлгийн эм зүйн салбарыг мэргэшсэн, ур чадвар бүхий хүний нөөцөөр тогтвортой ханган, эмийн зохистой хэрэглээний талаарх хэрэглэгчийн боловсрол дээшилнэ.
3. Олон улсын түвшинд шинжилгээ, баталгаажуулалт хийх чадавхи сайжирч, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторит түргэвчилсэн аргаар эмийн үлдэгдлийг тодорхойлох чадавхитай болно.
4. Дотоодын болон гадаадын зах зээлд худалдан борлуулах чиглэлээр бэлтгэсэн мах, сүүнд малын эмийн үлдэгдлийг тодорхойлох замаар хүнсний аюулгүй байдлыг хангана.
5. Малын эмийг зохих тун хэмжээгээр зааврын дагуу бичих, олгох, хэрэглэх дадлыг малын эмч нарт төлөвшүүлнэ.
6. Мал, амьтны эмийн нэгдсэн мэдээллийн сүлжээгээр эм, эмийн үлдэгдлийн хяналтыг хэрэгжүүлж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг нотлох мэдээллийн технологид суурилсан чадамжтай болно.

Хэрэгжих хугацаа. Хөтөлбөр нь 2019-2023 онд буюу 4 жилийн хугацаанд хэрэгжинэ.

ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ. Хөтөлбөрийн төлөвлөгөөний 2020 оны хэрэгжилт 72.0 хувьтай байна.

Үнэлгээний хувь	Арга хэмжээний тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
100	<u>14</u>	9	1	1	1	2
90	<u>11</u>	6	4	1	-	-
70	<u>18</u>	1	6	2	8	1
50	<u>7</u>	1	2	1	3	-

30	9	6	1	-	2	-
0	2	1	-	1	-	-
дундаж үнэлгээ	72.0	72.5	72.1	63.3	62.1	90.00



ДҮГНЭЛТ

1. Хөтөлбөрийн төлөвлөгөөний 5 зорилтын хүрээнд 61 арга хэмжээ хэрэгжүүлснээс хэрэгжилтийн дундаж үнэлгээ 72.0 хувьтай байна.
2. Тус хөтөлбөрт 2019 онд жилийн турш хэрэгжээгүй гэж үзэж хяналт-шинжилгээ хийсэн тул 2020 онд 2019 болон 2020 оны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.
3. Тус хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан баримт бичиг боловсруулах, батлуулахаар тусгагдсан эрх зүйн болон бусад зохицуулалтын шинж чанартай арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 69.7, сургалтын арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 70.0, гарын авлага бэлтгэх, түгээх арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 75.0, санхүүжилт нэн шаардлагатай 10 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 77.8 хувиар тус тус дүгнэгдэж байна.

ЗӨВЛӨМЖ.

1. Тус хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхдээ удирдлага зохион байгуулалтыг сайжруулж, нэн шаардлагатай арга хэмжээнд шаардагдах төсвийг улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх замаар хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газарт зөвлөмжилж байна.

МАЛЫН ЭМИЙН ҮЛДЭГДЛИЙН ХЯНАЛТЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

2020 он жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн хэрэгжилт	Үнэлгээ
1	1.1. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, худалдах, эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх, эмийн сангийн үйл ажиллагааны стандартуудыг шинэчлэн боловсруулах;	1. Мал эмнэлгийн эмийн сангийн бүтэц, үйл ажиллагаа MNS5545 : 2005;	2019		Стандартыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А-44 дүгээр тушаалаар "MNS 5545:2005 Мал, амьтны эмийн санд тавих нийтлэг шаардлага, стандарт" боловсруулах Мал эмнэлгийн ерөнхий газар, ХХААХҮЯ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Мал эмнэлгийн хүрээлэн, СХЗГ, МЭЭСБУЛ-ийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулснаар Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн С/19 дугаар тушаалаар "MNS 5545:2020 Мал, амьтны эмийн санд тавих нийтлэг шаардлага"-ыг батлуулсан.	100
2		2. Малын эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавих нийтлэг шаардлага MNS6461:2014;	2019		Стандартыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А-44 дүгээр тушаалаар "Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавих нийтлэг шаардлага" стандарт боловсруулах Мал эмнэлгийн ерөнхий газар, ХХААХҮЯ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Мал эмнэлгийн хүрээлэн, СХЗГ, МЭЭСБУЛ-ийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн С/19 дугаар тушаалаар "MNS 6461:2020, Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавих нийтлэг шаардлага"-ыг батлуулсан.	100
3		3. Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага MNS 5530: 2014 17;	2019		Стандартыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	"Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага" стандартыг шинээр боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна. Энэхүү стандартыг шинээр боловсруулж байгаа тул хэрэглэгч, малын эм ханган нийлүүлэх байгууллагууд болон малын эмийн үйлдвэрүүдтэй газар дээр нь танилцах, судалгаа хийх зайлшгүй шаардлагатай байдаг. Энэ судалгааны ажил Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан хойшлогдоод байна.	30
4		4. Монгол Улсын стандартын жагсаалт 2017 90 Малын эмийн	2019		Стандартыг шинэчлэн	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны өдрийн А/44 дүгээр тушаалаар Малын эмийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага стандартыг шинээр боловсруулах ажлын хэсгийг МЭЕГ, ХХААХҮЯ,	0

		үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага MNS 5524-2: 2014 7;			боловсруулж, баталсан байна.	МХЕГ, СХЗГ, МЭХ, МЭЭСБУЛ-ийн төлөөлөл оролцуулан томилж, холбогдох газруудын саналыг авч ажлын хэсгийн 2 удаагийн хурлыг зохион байгуулан ажиллаж байна. 2020 оны эхний хагас жилд багтаан стандартыг СХЗГ-т хүргүүлнэ.	
5		5. Эмийн чанарын хяналтын лабораторид тавих шаардлага MNS 6621:2016 23;	2019		Стандартыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	"Эмийн чанарын хяналтын лабораторид тавих шаардлага" стандартыг шинээр боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна. Энэхүү стандартыг шинээр боловсруулж байгаа тул хэрэглэгч, малын эм ханган нийлүүлэх байгууллага, малын эмийн үйлдвэр болон малын эмийн үйлдвэрийн дэргэдэх дотоодын чанарын хяналтын лабораторитой газар дээр нь танилцах, судалгаа хийх шаардлагатай байдаг. Энэ судалгааны ажил Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан хойшлогдоод байна. Ажлын хэсэг стандартын төслийг боловсруулж, саналыг нэгтгэж байна.	30
6		6. "Малын эмийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ыг боловсруулан, батлуулах;	2019		Журмыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	ХХААХҮЯ-ны 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/14 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар "Малын эмийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ыг, 2 дугаар хавсралтаар "Фармакопейн хорооны ажиллах журам"-ыг баталсан.	100
7	1.2. Мал, амьтны эмийн импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтад мөрдөж буй дүрэм, журам, заавар, жагсаалтыг шинэчлэх;	7. "Мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох лиценз олгох журам"-ыг боловсруулан, батлуулах;	2019		Журмыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	УИХ-ын 2002 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Эмийн талаар төрөөс баримтлах бодлого"-ын 1 дүгээр зүйлийн 2, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2.4, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2010 оны А/212 дугаар тушаалаар Мал эмнэлгийн зориулалттай малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөлтэй компаниудад 2011 оны 01 дүгээр сараас эхлэн олгогдож байна	90
8		8. "Мал эмнэлгийн фармакопейн хорооны ажиллах журам"-ыг боловсруулан, батлуулах;	2019		Журмыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А-14 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар Мал эмнэлгийн фармакопейн хорооны ажиллах журам батлагдсан	100
9		9. "Тусламж, хандиваар малын эм, эмнэлгийн хэрэгсэл хүлээн авах журам"-ыг боловсруулан, батлуулах;	2019		Журмыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	"Тусламж, хандиваар малын эм, эмнэлгийн хэрэгсэл хүлээн авах журам"-ыг боловсруулаад холбогдох газруудаас санал авч, хэлэлцүүлгийг зохион байгуулж байна. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн нэгдсэн бүртгэл мэдээлийн цахим санд бүх мэдээлэл орж байгаа. Тус харилцааг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн дагуу өмнө нь баталсан журмаар зохицуулж байна.	90
10		10. "Жороор олгох мал, амьтны эмийн жагсаалт, журам"-ыг боловсруулан, батлуулах;	2019		Журмыг шинээр боловсруулж, баталсан байна.	Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн бүртгэл мэдээлийн цахим сангийн хөгжүүлэлт хийгдэж байгаа тул энэ ондоо багтаан жороор олгох эмийн жагсаалтыг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.	30

11	11. “Мал, амьтны тэжээлийн нэмэлтийг бүртгэх, худалдах, эгүүлэн татах, импортын зөвшөөрөл олгох журам”-ыг боловсруулан, батлуулах;	2019		Журмыг шинээр боловсруулж, баталсан байна.	“Мал, амьтны тэжээлийн нэмэлтийг бүртгэх, худалдах, эгүүлэн татах, импортын зөвшөөрөл олгох журам”-ыг боловсруулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 12 дугаар 10-ны өдрийн А/456 дугаар тушаалаар батлуулан, 2020 оны 1 дүгээр сарын 15-нд Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
12	12. “Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтээс дээж авах, хураах, устгах, буцаах журам”-ыг боловсруулан, батлуулах;	2019		Журмыг шинээр боловсруулж, баталсан байна.	”Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтээс дээж авах, хураах, устгах, буцаах журам” боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна. Уг журмыг батлах субъект нь тодорхой бус учир "Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай" хуулийн төсөлд дээрх журмыг батлах субъектыг мал эмнэлгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэж оруулж байна.	30
13	13. “Мал, амьтны эм, эмийн хэрэглэгдэхүүн, тэжээлийн нэмэлтийн үйлдвэрт үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хугацаа сунгах, түдгэлзүүлэх, цуцлах журам”-ыг боловсруулан, батлуулах;	2019		Журмыг шинээр боловсруулж, баталсан байна.	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дахь заалт, 15.11.4 дэх заалт, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А-195 дугаар тушаалыг үндэслэн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаалаар Мал эмнэлгийн зориулалттай малын эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлт импортлох тусгай зөвшөөрлийг 2019 оноос олгож байна. Тусгай зөвшөөрлийн бүхий л зохицуулалт “Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл”-ийн тухай хуулийн зохицуулалтаар зохицуулагдаж байна.	100
14	14. “Зохистой дадлын нэвтрүүлсэн батламж олгох журам”-ыг боловсруулан, батлуулах;	2019		Журмыг шинээр боловсруулж, баталсан байна.	“Зохистой дадлын нэвтрүүлсэн батламж олгох журам” боловсруулах ажлын хэсгээс журмын төслийг боловсруулж, холбогдох газруудаас санал авахаар ажиллаж байна	30
15	15. “Малын эм бүртгэлийн дүрэм”-ийг боловсруулан батлуулах;	2019		Дүрмийг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	Малын эмийн бүртгэлийн журмын төслийг боловсруулж байна.	30
16	16. “Малын эмийн хэрэглэх зааврын загвар”-ыг боловсруулан, батлуулах;	2019		Загварыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	"Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн цахим сан"-д малын эмийн батлагдсан хэрэглэх зааврыг оруулахаар тусгасан. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа тул уг зохицуулалтар зохицуулагдаж байна.	70
17	17. “Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт”-ыг боловсруулан, батлуулах;	2019		Жагсаалтыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэгт заасны дагуу "Улсын бүртгэлд малын эм, эмийн түүхий эд бүртгэх, түргэвчилсэн журмаар бүртгэх, хугацаа төлбөр тогтоох, зарцуулах журам"-ыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А-49 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан. Малын эм, тэжээлийн нэмэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим сангийн хөгжүүлэлт дууссанаар журмыг шинэчлэхээр төлөвлөсөн.	90

18		18. “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, бэлдмэл болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”-г батлуулах;	2020		Үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг шинэчлэн баталсан байна.	"Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, бэлдмэл болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" стандартын төслийг FAO болон WHO-аас боловсруулан, баталж гаргадаг Codex alimentarius (international food standards) олон улсын стандартыг 1:1 харьцаагаар орчуулан боловсруулдаг. CAC (Codex alimentarius commission) нь 2020 онд "Maximum residue limits (MRLs) and risk management recommendations (RMRs) for residues of veterinary drugs in foods" стандартыг шинэчлэхээр төлөвлөсөн байсан ч олон улсад тархаад байгаа Covid-19 -ын нөхцөл байдлын улмаас 2021 он хүртэл хойшлогдоод байна. Иймээс хүнсний аюулгүй байдалтай холбоотой олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт / CAC (Codex alimentarius commission)/ батлагдсаны дараа "Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, бэлдмэл болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" стандартыг шинэчилнэ. Одоогийн хүчин төгөлдөр "Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, бэлдмэл болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" стандарт нь CAC (Codex alimentarius commission) стандарттай нийцэж байна.	90
19		19. “Мал эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн жагсаалт, хяналтын шошгоны бүртгэл, үйлдвэрлэл, импорт, экспорт, хадгалалт, худалдааг зохицуулах журам”-ыг боловсруулан, батлуулах;	2019		Журмыг шинээр боловсруулж, баталсан байна.	Мал эмнэлгийн ерөнхий газар, Хууль зүйн яам, Байгаль орчны яам, Малын эм ханган нийлүүлэх нийлүүлэх байгууллагын төлөөлөл оролцон мал эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн жагсаалт, хяналтын шошгоны бүртгэл, үйлдвэрлэл, импорт, экспорт, хадгалалт, худалдааг зохицуулах тухай хэлэлцүүлэг хийж, цаашид журмын төслийн боловсруулах судалгааны ажил хийгдэж байна. Тус журмыг Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн төслийг батлагдсаны дараа шинэчлэн батлуулахаар төлөвлөд байна.	50
20	1.3. Улсын болон орон нутгийн мал эмнэлгийн байгууллагын лабораториудад мөрдөж буй стандарт, журам, зааврыг шинэчлэх;	20. Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторит мөрдөж буй стандарт ажиллагааны зааврыг шинэчлэх;	2020		Стандарт ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	Нийт 450 стандарт ажиллагааны заавар мөрдөгддөгөөс энэ онд шинэчилсэн 56, шинээр боловсруулсан 81 стандарт ажлын заавар байна	100
21	лабораториудад мөрдөж буй стандарт, журам, зааврыг шинэчлэх;	21. Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторит мөрдөж буй стандарт ажиллагааны зааврыг шинэчлэх;	2020		Стандарт ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторийг лабораторийн MNS 17025:2018 стандартын шаардлагад нийцүүлэн чанарын гарын авлагын 24 төрлийн журмыг шинэчлэн баталж, мөрдөж байна.Тус лабораторийн баталгаажуулалтын алба нь MNS 17065:2013 стандартын шаардлагад нийцүүлэн чанарын гарын авлагын 23 төрлийн журмыг шинэчлэн баталж, мөрдөж байна.	100

22		22. Улсын хэмжээнд мал эмнэлгийн лабораториудын нэгдсэн стандарт ажиллагааны зааврыг боловсруулах;	2020		Стандарт ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори нь өөрийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа стандарт ажиллагааны зааврыг сүлжээ лабораторийн хүрээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Нийт 17 аймгийн мал эмнэлгийн лабораторийн чанарын гарын авлага, Менежментийн тогтолцооны дүрэм журам, Шилжилтийн үеийн төлөвлөгөө, Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, Өөрийгөө үнэлэх хуудас зэрэг бичиг баримтыг боловсруулаад байна.	90
23		23. Эмийн үлдэгдэл шинжлэх дээж авах аргачлалыг боловсруулан, батлуулах;	2020		Стандарт ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	Эмийн үлдэгдлийн шинжилгээнд дээж авах журам 1, шинжилгээний аргын стандарт 24 шинээр баталсан. Нийт 3 аргын баталгаажуулах удирдамж батлуулан, удирдамжийн дагуу Преми тест, Юнисенсорын арга болон хүнсний бүтээгдэхүүнд авермектиний бүлгийн эмийн үлдэгдэл тодорхойлох Өндөр мэдрэмжит шингэний хроматографийн арга (CA3/ХТА/ХҮ/20)-д баталгаажуулалт хийж, тайлагнав. Мөн хүнд металын дээж боловсруулах “Богино долгионы зууханд дээж боловсруулах” стандарт ажлын арга зүй боловсруулж батлуулав. Сүүнд тетрациклиний бүлгийн эмийн үлдэгдлийг иммуно-рецепторын аргаар тодорхойлох (CA3/ХТА/ХҮ/55-1) аргыг шинээр боловсруулж, аргын баталгаажилт хийгдсэн.	100
24	1.4. Эм, эмийн үлдэгдлийг илрүүлэх лабораторийн шинжилгээний нийтлэг аргачлалууд бүхий фармакопейн өгүүллүүдийг боловсруулах, батлан мөрдүүлэх.	24. Эм шалгах фармакопейн өгүүллүүдийг боловсруулах, батлах;	2019 - 2023		фармакопейн өгүүллүүдийг боловсруулж, баталсан байна.	"Мал эмнэлгийн фармакопейн өгүүлэл боловсруулах, батлах, дугаар өгөх, хүчингүй болгох" журмын төсөлд холбогдох газруудаас санал авч, нэгтгэн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А/321 дүгээр тушаалаар баталснаар Хуулийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд олон нийтэд сурталчлах зорилгоор олон нийтийн сүлжээнд нийтлэн, Нийслэлийн хэмжээнд 150 гаруй мал эмнэлгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, малын эмч, мэргэжилтэнд сургалт зохион байгуулсан болно. Шинээр 10 нэрийн малын эмийн үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл Фармакопейн хороогоор хэлэлцэгдэн батлуулахад бэлэн болсон. Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын боловсруулсан Малын эмийн ерөнхий фармакопейн өгүүлэл 5, аж ахуйн 4 нэгжийн үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл 21 тус тус хянагдан Фармакопейн хороогоор хэлэлцэхэд бэлэн болсон байна. /2020 оны 11-сараас хойш Covid -19 бүх нийтийн болон бэлэн байдлын зэрэгт шилжсэн шалтгаанаас хуралдаагүй/	90
ЗОРИЛТ 1							72.50
25	2.1. Аймаг, сум, аж ахуйн нэгжийн захиалгаар мал эмнэлгийн эм	25. Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын мэргэжилтнүүдэд эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай	2020 - 2023		500 мэргэжилтэн сургалтад хамруулсан байна.	Нийслэлийн Мал эмнэлгийн газартай хамтран дүүргийн мал эмнэлгийн мэргэжилтнүүдэд шинэчлэн батлагдсан MNS 5545:2020 Мал, амьтны эмийн санд тавих нийтлэг шаардлага, MNS 6461:2020, Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавих нийтлэг	30

	зүй, эмийн шинжилгээ, судалгааны чиглэлээр төгсөлтийн дараах болон мэргэшүүлэх, давтан сургалтыг лабораторийн орчинд зохион байгуулах;	хууль, захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, эм зүйн сургалт зохион байгуулах;				шаардлага стандарт болон эмийн зохистой хэрэглээ, нянгийн тэсвэржилт, эмийн үлдэгдлийн хяналтын талаар сургалт зохион байгуулсан.	
26	төгсөлтийн дараах болон мэргэшүүлэх, давтан сургалтыг лабораторийн орчинд зохион байгуулах;	27. Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтын улсын байцаагч нарт эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хууль, захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, эм зүйн сургалт;	2020 - 2022		60 улсын байцаагчийг сургалтад хамруулсан байна.	Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтын улсын байцаагч нарт эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн талаар онлайн хурлаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өдөр тутам өгч байна. Баян - Өлгий аймгийн сумдын мал эмнэлгийн тасгийн мал эмнэлгийн улсын байцаагч, тархвар зүйч, нийт малын эмч нарыг оролцуулсан танхимын болон ажлын байрны сургалт зохион байгуулж, Мал эмнэлгийн нэгдсэн систем, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд цахим гэрчилгээ олгох, баталгаажуулалт хийх, эмийн зохистой хэрэглээ, эмийн үлдэгдлийн хор уршигийн талаар дэлгэрэнгүй тайбарласан. Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газраас сумдын мэргэжилтнүүдэд 3 өдрийн ажлын байран дээрх сургалт, онлайн сургалтыг 5 удаа хийж, байгууллагын цахим хуудсаар дамжуулан өдөр тутмын мэдээллээр ханган ажиллалаа. Говьсүмбэр аймгийн МХГ-аас санаачилсан “Байцаагчийн үйл ажиллагаанд анхаарах асуудлууд, хамтын ажиллагаа” сэдэвт сургалтад мал эмнэлгийн хяналтын 3 улсын байцаагч хамрагдсан. Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын мал эмнэлгийн тасгийн байцаагч нарт Малын эмийн үлдэгдлийн хяналтын үндэсний хөтөлбөр, малын эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулсан. Дархан Уул аймгийн Мал эмнэлгийн газраас 2020 онд сумдын мал эмнэлгийн улсын байцаагч нар, мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн эмч нарт хэсэгчилсэн сургалтыг 4 удаа эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, захиргааны хэм, хэмжээний актын талаар зохион байгуулсан. Өмнөговь аймгийн МХГ-тай хамтран сумдын байцаагч, тархвар зүйч зүйч нарт нэг өдрийн сургалт зохион байгуулж, сумын байцаагч тархвар зүйч нийт 12 хүн оролцсон. Сургалтаар "хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих", "залилангийн хэрэг, цахим залилан түүнээс үүнээс сэргийлэх арга зам", хяналтын бодлого үйл ажиллагаа, үнэмлэх тэмдэг ашиглах журам", "Төрийн албан хаагчийн ёс зүй, мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага, албан бланк хэрэглэх, байцаагчийн гаргах акт баримт", гоц халдварт өвчний үед Мал эмнэлгийн байцаагчийн үүрэг, оролцоо сэдвийг хамруулсан.	90
27	2.2. Орчин үеийн шинжилгээний нарийн мэдрэмжтэй багаж	28. Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн лабораторийн нарийн мэргэжлийн шинжээч болон шинжлэгч эмч нарт	2020 - 2022		130 шинжээч эмчийг сургалтанд хамруулсан байна.	УМЭАЦГЛ-ийн шинжээчид Мерку Софс Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Хэнтий аймгийн Баянхутагт сумын нэгжийн малын эмч, хүчит шонхор захын лабораторийн эмч нарт био аюулгүй байдал, Мал эмнэлгийн магадлан шинжилгээний арга, антибиотикийн үлдэгдэл тодорхойлох E-reader, Explorer 2.0 тестын талаар	90

	төхөөрөмж дээр ажиллаж экспорт, импортын бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн шинжилгээг гүйцэтгэж баталгаа гаргадаг нарийн мэргэжлийн шинжлэгч нарыг давтан сургах, тэдгээрийн хүрэлцээ, хангамжийг сайжруулах;	эмийн үлдэгдлийн сургалт зохион байгуулах;				7 хоногийн ажлын байрны сургалт явуулсан. Мерси кор олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалтын хүрээнд Хэнтий аймгийн Баянхутаг сумын 3 эмч, Хүчит Шонхор худалдааны төвийн малын их эмч 1 УМЭАЦТЛ-т 10 хоног суралцан лабораторийн дадлага хийх хугацаандаа эмийн үлдэгдлийн шинжилгээний арга зүй эзэмшив. Төв аймгийн МХГ болон тасгийн улсын байцаагч нарт эмийн үлдэгдэл, тодорхойлох арга аргачлал эзэмшүүлэв. Швейцарийн хөгжлийн агентлаг “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төслийн ажлын хүрээнд 10 аймгийн 26 сумын нэгжийн эмч нарт зориулсан Мал эмнэлгийн эмийн үлдэгдлийн хяналтын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх нь сэдэвт онолын болон лабораторийн дадлага эзэмшүүлэх ажлын байран дах сургалт зохион байгуулсан. Синапс ХХК-аас эмийн үлдэгдэл тодорхойлох багаж, оношлуурыг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр худалдан авч, хэрэглэх арга зүй эзэмшүүлэх сургалтыг ажлын байранд зохион байгуулах гэрээний дагуу лабораторийн 4 эмч, хүнсний захын лабораторийн 1 эмч, мөн ШХА-н "Ногоон алт малын эрүүл мэнд төслийн хүрээнд Чандмань, Дэлгэр сумын 9, нийт 14 эмч сургалтад хамрагдлаа. Өмнөговь аймгийн Мал эмнэлэг, ариун цэвэр, магадлан шинжлэгч эмч М.Лхамцэцэгийг Нийслэлийн мал эмнэлгийн газарт 14 хоногийн хугацаатай мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд антибиотик тодорхойлох ажлын байран дахь сургалтад хамруулсан.	
28		29. Худалдааны захын мал эмнэлгийн лабораторийн шинжлэгч эмч нарт эмийн үлдэгдлийн онол, арга зүйн сургалт зохион байгуулах;	2020 - 2023		100 шинжээч эмчийг сургалтанд хамруулсан байна.	Хүчит шонхор худалдааны төвийн нэг малын их эмч УМЭАЦТЛ-т 21 хоног суралцан, эмийн үлдэгдлийн шинжилгээний арга зүй эзэмшив. Говь-Алтай аймагт Синапс ХХК-аас эмийн үлдэгдэл тодорхойлох багаж, оношлуурыг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр худалдан авч, хэрэглэх арга зүй эзэмшүүлэх сургалтыг ажлын байранд зохион байгуулах гэрээний дагуу лабораторийн 4 эмч, хүнсний захын лабораторийн 1 эмч хамрагдлаа. Дархан Уул аймагт Хүнсний захын дэргэдэх мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн шинжлэгч эмч нарт малын маханд эмийн үлдэгдэл /антибиотик/-ийг үзэх түргэвчилсэн оношлуурын сургалт зохион байгууллаа. Өмнөговь аймгийн Булган, Сэврэй, Мандал-Овоо, Ханбогд сумын малын эрүүл мэндийн төв, анхан шатны лабораторийн эмч нарт мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд антибиотикийн үлдэгдэл тодорхойлох 3 хоногийн ажлын байрны сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 12 малын эмч мэргэжилтэн хамруулсан.	70
29		30. Олон улсын байгууллагуудтай хамтран орчин үеийн шинжилгээний арга зүй	2020 - 2023		50 шинжээч эмчийг сургалтад	Онлайн сургалт Лабораторийн шинжээс эмч нар ДМАЭМБ -аас "The regional consultations about African Horse Sickness preparedness", ОУАЭА-аас "The programme and scope of R&D at the Animal Production and Health Laboratory of the Joint FAO/IAEA Division" зэрэг байгууллагаас зохион	70

		<p>ээмшүүлэх сургалтанд улс, аймаг, нийслэлийн лабораторийн шинжээч эмч нарыг сургах арга хэмжээг зохион байгуулах;</p>			<p>хамруулсан байна.</p>	<p>байгуулсан онлайн сургалтад хамрагдав. Денверийн зоологийн сангаас зохион байгуулсан зэрлэг амьтны мал эмнэлэг онлайн сургалтад 1. “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлал, 2. Халдварт өвчнийг судлах гарын авлага, 3. Өвчний тохиолдлыг бодит жишээн дээр а. Баруун Нилийн вирусын халдвар, b. Замаг хэт ихсэх (хордлого), с. Хонины микоплазмын халдвар, Хор судлал, Бодис солилцооны хямрал (мал, тэжээвэр амьтанд эрдэс бодис, витамин дутагдах), Шимэгч судлал, Хээрийн нөхцөлд задлан хийх, Нөхөн үржихүй Цацраг судлагч шинжээс ОУАЭА-аас зохион байгуулж байгаа Virtual Event - On-Line Regional Training Course in data analysis for food authentication using the Chemometric Add-ins for Excel (CAFE) software сэдэвт сургалтад оролцов.</p> <p>Өмнөговь аймагт Мал эмнэлгийн үйлчилгээний 34 нэгжийн эмч, газрын 10 эмч ажилтанд зориулсан “Жижиг амьтны мэс ажилбарын сургалт, дадлага”-ыг 09 дүгээр сарын 04-нд Монгол Ви Ти НеТ ТББ-ын Энэрэх Мал эмнэлгийн сургалтын төвийн ерөнхий малын их эмч, дарга Н.Гантуяа, Зөвлөх малын их эмч Жастин Вүүлси нар “нохой, муурны халдварт өвчин, шингэний эмчилгээ, дотор гадна паразит, түүний эмчилгээ, нохой бэхлэх аргууд, нохойн наркозын бэлдмэлүүд, тэдгээрийн хэрэглээ, охин нохойн үржил хаах ажилбар” сэдвээр дадлага ажил, танхимын сургалтыг онолын болон дадлага хэлбэрээр явуулж Мал эмнэлэг үйлчилгээний нэгж, Мал эмнэлгийн тасгийн малын эмч, мэргэжилтэн нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадавхжуулахад ач холбогдол бүхий сургалт, дадлага боллоо.</p>	
30	<p>2.3. Малчид, мал бүхий иргэд, махны үйлдвэрийн болон хүнсний захын ажилчдын малын эм, эмийн үлдэгдэл, түүнээс сэргийлэх, сэрэмжлүүлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх;</p>	<p>31. Аймаг, сумын малчдын зөвлөгөөнд эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хууль, захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, эмийн үлдэгдэл, түүнээс сэргийлэх, сэрэмжлүүлэх сургалтыг зохион байгуулах;</p>	<p>2020 - 2023</p>		<p>10000 малчдыг сургалтанд хамруулсан байна.</p>	<p>Швейцарийн хөгжлийн агентлаг “Ногоон алт малын эрүүл мэнд” төслийн хүрээнд 10 аймгийн 26 суманд 2020 оны 07 дугаар сарын 24-нөөс 8-р сарын 21-ний хооронд Мал эмнэлгийн эмийн үлдэгдлийн хяналтын үндэсний хөтөлбөр, Эмийн зохистой хэрэглээ, Малын эмийн үлдэгдлийн талаарх ойлголт өгөх сургалт хийж, нийт 87 малын эмч, 863 малчин, мал бүхий иргэд хамрагдав.</p> <p>Говь-Алтай аймгийн нийт 17 сумын 217 малчинд малын эм, эмийн үлдэгдлийн талаар хот айлын түвшинд яриа танилцуулга хийж, өөрсдийнх нь гар дээр хэрэглэгдэж байгаа эмийн байдалд асуумж судалгаа авч эрсдлийн үнэлгээ хийлээ. Нийт малчдын 83% нь гэрээт малын эмчээсээ, 7% хувь нь малын эмийн сангаас, 10% нь хотоос авдаг гэж хариулсан байна. Малын эмийг зааврын дагуу хэрэглэж, хадгалдаг уу гэсэн асуултад судалгаанд хамрагдсан малчдын 72% нь тийм, 28% нь зааврын дагуу хэрэглэдэг ч хадгалалтын горимыг зөрчдөг гэж хариулсан байна. Малчдын худалдан авдаг эмийн төрөлд судалгаа авахад шимэгчтэх өвчний үед хэрэглэдэг ивермектин 190 малчин, туулгалтын эмийг 99 малчин, угаалгын бодис 48 малчин худалдан авч малдаа хэрэглэдэг гэж хариулжээ. Харин пенициллины бүлгийн антибиотик 175 малчин,</p>	70

					тетрациклины булгийн антибиотик 113 малчин худалдан авдаг гэсэн байна. Малын гэжээлийн нэмэлт бүтээгдэхүүн 91 малчин худалдан авдаг гэж хариулжээ. Судалгаанд хамрагдсан малчдын хариултаас дүгнэлт хийхэд гэрээт малын эмчээс худалдан авалт хийдэг, худалдан авсан эмийн хэмжээ их биш, зөвхөн өвдсөн малдаа хэрэглэгдэг зэрэг нь эмийн хэрэглээ их биш байгааг харуулж байна. Мөн гэжээлийн нэмэлт бүтээгдэхүүнийг зөвхөн хурдан моринд хэрэглэдэг байна. Гэвч малын эмийн хэрэглээг хянах зорилгоор малын маханд ивермиктин болон антибиотикын үлдэгдэл тодорхойлох шинжилгээг энэ онд 218 дээжинд хийсэн. Дархан Уул аймгийн Хонгор суманд 2020 онд зохион байгуулагдсан Залуу малчдын зөвлөгөөнөөр 150 гаруй малчинд эмийн зохистой хэрэглээ, холбогдох хууль тогтоомжийн талаар танилцуулсан. Өмнөговь аймаг нийт 4200 малчинд мэдээлэл өгсөн байна.	
31	32. Мах, сүү боловсруулах үйлдвэр, цехийн удирдлага, ажилтнуудад эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хууль, захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, эмийн үлдэгдэл, түүнээс сэргийлэх, сэрэмжлүүлэх сургалтыг зохион байгуулах;	2020 - 2023	80 удирдлага, ажилтнуудыг сургалтанд хамруулсан байна.	2020 онд Нийслэл болон 4 бүсийн аймгийн махны үйлдвэрийн нийт 190 гаруй малын эмч, улсын байцаагчийг "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөл" сэдэвт сургалтад хамруулсан. Баян-Өлгий аймагт Мал төхөөрөх үйлдвэрт ажиллаж байгаа, ажиллах гэрээт малын эмч, технологич нарыг мэргэшүүлэх, гэрчилгээ олгох "Мах, махан бүтээгдэхүүний мал эмнэлэг ариун цэврийн нөхцөл" сэдэвт Мал эмнэлгийн ерөнхий газар, АХБ-ны "Хөдөө аж ахуйн өртөгийн сүлжээг дэмжих" техник туслалцааны сургалтад хамруулсан. Уг сургалт Ховд аймагт зохион байгуулагдаж, тус аймгаас 5 мал төхөөрөх үйлдвэрийн малын эмч, хүнсний асуудал хариуцсан мэргэжилтэн, үйлдвэр хариуцсан мал эмнэлгийн улсын байцаагч 13 малын эмч, мэргэжилтэн оролцсон. Сургалтаар "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрийн технологи" өргөн сэдвээр хичээл заагдаж, махны үйлдвэрт очиж дадлага хийсэн болно. Мөн мал төхөөрөх үйлдвэрт ажиллаж байгаа гэрээт малын эмч, технологич нарт сертификат өгсөн. Энэ сургалтын үеэр аймгийн мал эмнэлгийн улсын байцаагч MNB Монголын мэдээ "Орон нутагт үйлдвэрийн аргаар мах, махан бүтээгдэхүүн бэлтгэх, экспортлах" ажлын талаар мэдээлэл өгсөн. Говь-Алтай аймагт Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Монгол Улсын MNS6688;2017 стандарт, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм зааврын талаар аймагт үйл ажиллагаа явуулж буй мах боловсруулах үйлдвэрийн 3 малын эмчид сургалт зохион байгууллаа. Сургалтаар маханд антибиотикийн үлдэгдэл тодорхойлох арга зүйг эзэмшүүлэн, гарын авлага, холбогдох материалыг өгсөн. Дархан Уул аймагт Мал эмнэлгийн ерөнхий газар, АХБ-ны ХАА-н Өртгийн Сүлжээг дэмжих төсөл, SECIM төсөлтэй хамтран "Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи мал эмнэлэг ариун цэврийн нөхцөл" сэдэвт төвийн бүсийн сургалтыг зохион байгуулсан. Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж буй Гүүд рүүт интер трейдинг ХХК-ний	70	

					махны үйлдвэрт мал нядлахын өмнөх үзлэг хийж байгаа байдал, мал төхөөрөх дамжлага, үйлдвэрийн тоног төхөөрөмж үйл ажиллагаатай танилцаж, хяналтын хуудсаар үнэлсэн	
32		33. Хүнсний захын ажилчдын эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хууль, захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, эмийн үлдэгдэл, түүнээс сэргийлэх, сэрэмжлүүлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх;	2020 - 2022	1000 ажилчдыг сургалтанд хамруулсан байна.	Мал эмнэлгийн ерөнхий газраас "Алтан үе Буянт" ХХК-тай "Малын мах, дайвар бүтээгдэхүүнд эмийн бодисын үлдэгдэл илрүүлэх сорилт шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх гэрээ" байгуулж, орон нутгаас Улаанбаатар хотын зах, худалдааны төвд тээвэрлэгдэн ирсэн маханд эмийн бодисын үлдэгдэл илрүүлэх сорилт шинжилгээний судалгааг Нарантуул-2 худалдааны төвийн дэргэдэх лабораторид давхардсан тоогоор 8 аймаг, 26 сумаас худалдан борлуулсан малын махнаас нийт 371 сорьц цуглуулан дүгнэлт гаргасан. Хэнтий, Булган, Сэлэнгэ аймгийн 15 малын эмчид малын маханд эмийн бодис илрүүлэх шинжилгээ хийх аргыг биечлэн үзүүлж, мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээний мэдээллийг үнэн зөв бичээгүйн улмаас үүсэх эрсдэлийн талаар бодит жишээн дээр тайлбарласан. Малын маханд эмийн бодисын үлдэгдэл илрүүлэх сорилт шинжилгээ хийх арга зүй боловсруулан лабораторийн эмч нарт сургалт зохион байгуулж, багаж төхөөрөмж ажиллуулах, оношлогооны цомгийн хадгалалт хамгаалалт, шинжилгээ баталгаажуулалт хийх талаар шинжлэгч эмч нарыг дадлагажуулж гарын авлага материалаар хангасан. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчид Малын гаралтай мах махан бүтээгдэхүүн боловсруулах Зергер, Угур, Нөхөд ХХК болон "Тирлик" хүнсний захын мах, сүү, цагаан идээ худалдаж буй иргэдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт-шалгалтыг хийсэн. Мөн худалдаа эрхэлж буй иргэдэд эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, эмийн үлдэгдэл, түүнээс сэргийлэх талаар сэрэмжүүлэг хуудас тарааж, ил задгай худалдаа хийхгүй байхыг анхааруулж, мэдээ мэдээллээр хангаж ажиллав. Говьсүмбэр аймагт Малын эмийн үлдэгдлийн хяналтын үндэсний хөтөлбөр, малын эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдын малчин өрхийн 145 иргэн, мал нядалгааны цэг, хүнсний захын түүхий махны лангуу түрээслэгч 15 иргэн, аймгийн хэмжээнд 160 иргэнтэй уулзаж, малын эмийн зохистой хэрэглээний талаар зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.	70
33	2.4. Мал эмнэлгийн эм зүй, фармакогнози, эмийн технологи, эмийн маркетинг болон эмийн	34. Эмийн бүртгэлийн жагсаалтын эмхэтгэл	2020 - 2023	3000 ширхэгийг хэвлэн, мэдээллийг түгээсэн байна	"Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн нэгдсэн бүртгэл мэдээллийн цахим сан"-гийн хөгжүүлэлт хийгдэж байна. Энэ цахим сангийн хөгжүүлэлтээр малын эмийн улсын бүртгэлд бүртгэлтэй, Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторийн дүгнэлттэй, хэрэглэх заавар бүхий мэдээллийг оруулахаар ажиллаж байна. "Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн нэгдсэн бүртгэл мэдээллийн цахим сан"-гийн хөгжүүлэлтэд мал эмнэлгийн зориулалттай малын эм, тэжээлийн нэмэлт импортлох тусгай зөвшөөрөлтэй компаниудын малын	90

	эдийн засгийн сурах бичгүүдийг зохиох, хэвлэх, нийтийн хүртээл болгох.				эмийн улсын бүртгэлд бүртгэлтэй 460 гаруй эм, бэлдмэлийн танилцуулга, хэрэглэх заавар, МЭЭСБУЛ-ийн шинжилгээний дүгнэлт, тухайн эм, бэлдмэлийн үйлдвэрлэгчийн танилцуулга, хаяг, шошго, сертификат, бүртгэлийн гэрчилгээ зэргийг цахим санд байршуулаад байна. Гүйцэтгэгч Ооллинк компани, МЭЭСБУЛ-той хамтран тусгай зөвшөөрөлтэй компаниудад цахим сангийн хөгжүүлэлтээр 3 удаагийн сургалт зохион байгуулсан.	
34	35. Мал эмнэлгийн фармакопейн өгүүллийн товхимол	2020 - 2022		3000 ширхэгийг хэвлэн, мэдээллийг түгээсэн байна	"Мал эмнэлгийн фармакопейн өгүүллийн товхимол" бэлтгэх зорилгоор өмнө нь батлагдсан фармакопейн 240 өгүүллийг word файлын форматад оруулж, эх бэлтгэсэн. Мөн фармакопейн өгүүлүүдийг "Малын эмийн нэгдсэн мэдээллийн сан"-д оруулахаар ажиллаж байна.	70
35	37. Жороор олгох болон жоргүйгээр олгох эмийн жагсаалт	2020 - 2022		3000 ширхэгийг хэвлэн, мэдээллийг түгээсэн байна	"Жороор олгох мал, амьтны эмийн жагсаалт," "Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт", "Жор бичилтийн загвар, маягт"-ын загварын төслийг шинэчлэн боловруулах ажлын хэсэгийг байгуулан ажиллаж байна. "Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн нэгдсэн бүртгэл мэдээллийн цахим сан"-гийн хөгжүүлэлтэд оруулсан малын эмийн улсын бүртгэлтэй эмийг жороор олгох, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтаар ангилан 2021 оны эхний хагас жилд багтаан батлуулахаар ажиллаж байна.	50
36	39. Эмийн түгээлт, хадгалалт, устгалын гарын авлага	2020		2000 ширхэгийг хэвлэн, мэдээллийг түгээсэн байна	"Малын эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг бүртгэх, эгүүлэн татах" журам ХХААХҮ-ийн сайдын тушаалаар батлагдсан. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/178 дугаар тушаалаар батлагдсан "Малын эмийн үлдэгдлийн хяналт"-ын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний нэгдүгээр зорилтын 1.2.12 дэх хэсгийг үндэслэн "Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтээс дээж авах, хураах, устгах, буцаах журам" боловсруулах ажлын хэсэг журмын төслийг боловсруулаад байна. Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн төсөлд уг зохицуулалтыг нэмж тусгуулахаар ажлын хэсэгт санал хүргүүлэн ажиллаж байна.	50
37	40. Эмийн үлдэгдэл, түүнээс сэргийлэх, сэрэмжлүүлэх нугалбар танилцуулга	2020 - 2023		5000 ширхэгийг хэвлэн, мэдээллийг түгээсэн байна	НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр нянгийн тэсвэржилт, эмийн үлдэгдэл, түүнээс сэргийлэх, сэрэмжлүүлэх зурагт хуудас 4000 ширхэг хэвлэж бэлтгэсэн. Баян-Өлгий аймагт Малын эмийн үлдэгдэл болон зарим төрлийн антибиотیکیг зохистой хэрэглэх, малын эмчийн заавраар бус дур мэдэн малын аливаа өвчний эм бэлдмэл хэрэглэхгүй байх талаар малчид, иргэдэд сурталчлан ажилласан ба сэрэмжлүүлэг хуудас тараасан. Говь-Алтай аймгийн Засаг даргын А/211 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газар, Дэлхийн Зөн ОУБ хамтран аймгийн 88 багт хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх "Аяны богц"-нд эмийн талаарх нугалбар бэлтгэж хийж, сурталчиллаа Дархан Уул аймагт "Антибиотیکیн зохистой хэрэглээ, эмийн үлдэгдэлээс сэргийлэх" нугалбар бэлтгэн 500 гаруй малчдад хүргэсэн.	100

					Өмнөговь аймагт малчид болон нэгийн түвшинд хэрэглэж байгаа эмийн хэрэглээнд хяналт хийх, нэгжийн эмийн гарал үүслийг тогтоох, эмийн жагсаалтад ороогүй болон хугацаа дууссан, чанар байдлаа алдсан эм бэлдмэл хэрэглэж байгаа эсэхийг тогтоож, арга хэмжээ авах тухай удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж, 14 сумын 31 мал эмнэлгийн нэгж, 9 сумын 112 малчин өрхийн хэрэглэж байгаа малын эм, бэлдмэлд хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар: хаяг шошго нь тодорхойгүй, ямар эм бэлдмэл болох нь тодорхой бус, Монгол улсын эмийн бүртгэлд бүтгэгдээгүй эм бэлдмэл хэрэглэж байгаа тохиолдол илрээгүй байна. 2. Малын эмийн замбараагүй хэрэглээнээс татгалзах, баталгаатай эмийн сангаар үйлчлүүлэх, эмийн эмх замбараагүй буруу хэрэглээнээс үүдэлтэй гарах эрсдэлийн тухай 2 төрлийн тараах материалыг малчид, мал бүхий иргэдэд багийн иргэдийн нийтийн хурлаар тараасан.	
38	42. Мал эмнэлгийн эмийн хууль эрх зүйн эмхэтгэл	2020	3000 ширхэгийг хэвлэн, мэдээллийг түгээсэн байна	Мал эмнэлгийн эм зүй, фармакогнози, эмийн технологи, эмийн маркетинг болон эмийн эдийн засгийн сурах бичиг зохиох, хэвлэх, нийтийн хүртээл болгохоор олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. "Малын эмийн хэрэглэх заавар"-ыг шинэчлэн эмхэтгэн хэвлүүлэхээр ажиллаж байна. "Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн нэгдсэн бүртгэл мэдээллийн цахим сан"-гийн хөгжүүлэлтэд малын эмийн холбогдолтой эрх зүйн баримт бичиг, дүрэм, журам, шинэчлэн батлагдсан "Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS 6461:2020", "Мал, амьтны эмийн санд тавигдах ерөнхий шаардлага MNS 5545 2020" стандартыг цахим хэлбэрээр байршуулсан. Малын эмийн хэрэглэх зааврыг шинэчлэн эмхэтгэж, 2021 онд багтаан хэвлүүлэхээр ажиллаж байна.	90	
ЗОРИЛТ 2					72.14	
39	3.1. Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эдэд /мах, сүү, зөгийн бал, гэх мэт/ эмийн үлдэгдэл бодис тодорхойлох лабораториудыг бэхжүүлэх;	43. Эмийн үлдэгдэл бодис тодорхойлох оношлуур, урвалжаар хангах;	2020 - 2023	Оношлуур, урвалжаар хангасан байна.	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид тендерээр 2020 онд шаардлагатай байгаа 6 нэр төрлийн 29 оношлуур нийлүүлж, шинжилгээнд хэрэглэж байна. ШХА-ийн "Ногоон алт малын эрүүл мэнд" төслийн санхүүжилтээр мах, сүүнд антибиотикийн үлдэгдэл тодорхойлох премитестийн багажийг Баян Өлгий аймгийн Улаанхус, Буянт сумдын мал эмнэлгийн тасагт хүлээлгэн өгсөн. Говь-Алтай аймагт 3 төрлийн ELISA цомог 3.6 сая /Streptomycin, Tetracyclin, Chloramphenicol/, 100 сорьцын Преми тест 1.5 сая, нийт 5.1 сая төгрөгийн оношлуураар шинжилгээ хийгдлээ. Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2020-2021 онд хэрэгжүүлэх 4 зорилт 11 арга хэмжээ бүхий "Малын эрүүл мэнд дэд хөтөлбөр"-ийг АИТХ-ын 2019 оны 31 дүгээр тогтоолоор батлуулсан. Тус хөтөлбөрийн хүрээнд мал, амьтны гаралтай түүхий мах сүүнд эмийн үлдэгдэл тодорхойлох ЭЛИЗА шинжилгээ хийхэд шаардлагатай хлорфениколын бүлгийн антибиотик	90

					болон ивермектиний үлдэгдэл илрүүлэх цомог тус бүр 1, преми тест 100 ширхэгийг худалдан авсан. Дархан Уул аймгийн Засаг дарга, төсөл хөтөлбөрийн хүрээнд мах, махан бүтээгдэхүүнд эмийн үлдэгдэл тодорхойлох багаж төхөөрөмж нийлүүлж, жилийн хэрэгцээний оношлуур, тестээр хангасан. Өмнөговь аймагт Маханд антибиотик илрүүлэх, сүүнд антибиотикийн төрөл тодорхойлох цомгийг 2020 оны 12 дугаар сард "Монветмед" ХХК-аас худалдан авалт хийхээр гэрээ байгуулж захиалаад байна.	
40		44. Эмийн үлдэгдэл бодис тодорхойлох багаж төхөөрөмжөөр хангах;	2020	Багаж, төхөөрөмжийг нийлүүлсэн байна.	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори Цөмийн технологи дээр суурилсан шинжилгээний арга ашиглан хүнсэн дэх химийн/байгалийн бохирдуулагчид, түүний дотор байгальд тохиолдож болох мал эмнэлгийн эмийн үлдэгдлийг илрүүлэх лабораторийн чадавх бэхжүүлэн, олон улсын зах зээл дээр малын гаралтай бүтээгдэхүүнийг экспортлоход өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор Олон улсын цөмийн энергийн агентлагийн техник хамтын ажиллагааны төсөлд хамрагдан ажиллаж байгаа ба төслийн хүрээнд Нарийн мэдрэмжит багаж төхөөрөмж болох нийт 204.900.00 еврогийн үнэ бүхий шингэний хроматограф хосолсон масс детектортой багаж (LC-MS/MS), нийт 55,593.21 еврогийн үнэ бүхий CHARMII (radio immune receptor assay) багаж болон дагалдах бусад хангамжийг бүрдүүлэх замаар шинжилгээний хэрэгсэл/багаж төхөөрөмжийн хангамжийг бэхжүүлснээр улс орны хэмжээнд бүхэлд нь хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг найдвартай баталгаатай шинжлэх техникийн хүчин чадлыг бий болголоо.	100
41		45. Эмийн үлдэгдэл бодис тодорхойлох арга, аргачлалыг бүсэд ажиллаж буй аймгийн лабораторит нэвтрүүлэх;	2020 - 2023	3 аймагт эмийн үлдэгдэл тодорхойлох арга, аргачлалыг нэвтрүүлсэн байна.	COVID оос шалтгаалан сургалт хийгдээгүй.	0
42	3.2. Малын эмийн чанарын болон мал эмнэлгийн эмийн	46. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийг олон улсын болон бүсийн итгэмжлэлд хамруулах;	2020 - 2023	1 лабораторийг итгэмжлүүлсэн байна	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийг MNS ISO/IEC 17025:2018 стандартын итгэмжлэлд хамруулан, гэрчилгээг 2023 оныг хүртэл 3 жилийн хугацаатайгаар баталгаажуулсан.	70
43	үйлдвэрүүдийн хяналтын лабораториудыг үндэсний болон олон улс, бүс нутгийн	48. Эмийн үйлдвэрийн лабораторийг итгэмжлэлд хамруулах;	2020	9 лабораторийг итгэмжлүүлсэн байна.	"Биокомбинат" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Дотоодын чанарын хяналтын лаборатори нь MNS ISO 17025-2014 стандартын дагуу итгэмжлэлийн материал бүрдүүлэн Стандарт хэмжилзүйн газарт хүргүүлээд байна.	50

	итгэмжлэлд хамруулах;						
44	3.3. Эм, эмийн болон химийн бодисын хаягдалын менежментийг төлөвшүүлэх замаар хүн, байгаль орчинд нөлөөлөх мал эмнэлгийн эмийн сөрөг үйлчилгээг бууруулах.	52. Мал эмнэлгийн эмийн хортой болон аюултай бодисын тэмдэг, тэмдэглэгээг хийх	2020		Тэмдэг, тэмдэглэгээний загварыг боловсруулан, харьяа байгууллага, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн лабораторит мөрдүүлсэн байна.	Байгаль, орчин аялал жуучлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2020 оны А/125, А-69, А/143 дугаартай хамтарсан тушаалын 3 дугаар хавсралтаар багтсан хлорын шохой (8000 кг), роксид (7000 кг), суперкилл (7200 кг) бодисыг нийлүүлэх гэрээг МЭТШ/2020/03/007-I багцын тендерт шалгарсан “Тэнүүнхишиг” ХХК, Мал эмнэлгийн ерөнхий газар хооронд байгуулсан гэрээ, хуваарийн дагуу аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газарт нийлүүлсэн. Бусад эм, бэлдмэл нь үйлдвэрлэгчийн тэмдэг, тэмдэглэгээтэй хэрэглээнд гарч байгаа болно.	70
ЗОРИЛТ 3							63.33
45	4.1. Мал эмнэлгийн эмийн сан, эмийн үйлдвэр, эмийн шинжилгээ, баталгаажуулалтын лабораториудад олон улсын болон үндэсний стандартуудыг нэвтрүүлэх, мөрдүүлэх;	53. Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторид олон улсын шинжилгээний арга, аргачлалыг нэвтрүүлэх, итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлэх;	2020 - 2023		Баталгаажуулах шинжилгээнд зориулж хосолсон масс детектиртэй шингэний хроматограф, ШАМП аргуудыг нэвтрүүлсэн байна.	Коронавируст халдвар (COVID-19)-ын үед мал эмнэлгийн салбарын байгууллагуудад баримтлах түр зааврыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А-277 дугаар тушаалаар батлуулан мөрдөж байна. УМЭАЦТЛ УТҮГ-ын итгэмжлэлийн хүрээг 2020 онд 50 арга аргачлалаар нэмэгдүүлсэн.	50
46	баталгаажуулалтын лабораториудад олон улсын болон үндэсний стандартуудыг нэвтрүүлэх, мөрдүүлэх;	54. Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын лабораторид олон улсын шинжилгээний арга, аргачлалыг нэвтрүүлэх, итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлэх;	2020 - 2023		Атом шингээлтийн спектрофотометр багажийг нэвтрүүлж, эмэнд агуулагдах макро, микро элементийг илрүүлж, хэмжээг тогтоодог болсон байна.	МЭЭСБУЛ УТҮГ нь 2017 онд 11 төрлийн 376 нэр бүхий эм, биобэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүнд чанарын баталгаажуулалт хийж байсан. МЭЭСБУЛ-ийн Баталгаажуулалтын алба нь “Стандарт хэмжилзүйн газар”-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/150 дугаар тушаалаар MNS ISO/EIC 17065:2013 стандарт, Сорилтын лаборатори нь “Стандарт хэмжилзүйн газар”-ын даргын 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/172 дугаар тушаалаар MNS ISO/EIC 17025:2018 стандартын дагуу итгэмжлэгдэн, 434 нэр бүхий эм биобэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүнд чанарын баталгаажуулалт хийхээр итгэмжлэлийн хүрээг шинэчлэн батлуулсан.	70

47		55. Аймаг, нийслэлийн лабораториудад үндэсний болон олон улсын шинжилгээний аргын стандартуудыг нэвтрүүлэх, бэлтгэлийг хангуулах;	2020 - 2022		Үнэлгээний хувиар	<p>Хэнтий аймгийн мал эмнэлгийн лабораторид Мах, элэг, бөөр, өндөг, тэжээлд антибиотикийн үлдэгдэл илрүүлэх Explorer 2.0 тестийн стандарт ажлын зааврыг 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр батлан мөрдүүлж байна.</p> <p>Говь Алтай аймгийн мал эмнэлгийн лабораторид МХЕГ-ын хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 2016 оны 02 дугаар сарын 05 өдрийн Преми-Тестийн аргаар мах, өндөг, малын тэжээлд антибиотикийн үлдэгдэл илрүүлэх Стандарт ажлын заавар, Антибиотикийн үлдэгдэл тодорхойлох MNS 6665-2017 стандартыг нэвтрүүлсэн.</p> <p>Говьсүмбэр аймгийн Мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори Сүлжээ лабораторийн Vet.shinjilgee.mn сайтын шинэчлэгдсэн хувилбар болох Vetlab.shinjilgee.mn-нд 2020 оны 3-р улирлаас эхлэн бүрэн шилжиж лабораторийн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн. Мөн "Шинэчлэгдсэн Vetlab.shinjilgee.mn сайтад ажиллах" тухай УМЭАЦТЛ-оос зохион байгуулсан цахим сургалтад лабораторийн 2 албан хаагч хамрагдсан.</p> <p>Дархан Уул аймгийн Мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори MNS ISO/IES 17025 Сорил болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага стандартад заасны дагуу чанарын гарын авлага, дагалдан гарах менежментийн тогтолцооны журам, дүрмийг сүлжээ байдлаар УМЭАЦТЛ болон аймгийн лабораторийн эрхлэгч нараас бүрдсэн ажлын хэсэгт оролцон боловсруулсан. Үндэсний итгэмжлэлийн төвд "Итгэмжлүүлэхээр хүсэлт гаргах өргөдөл" хүргүүлсэн. Тус төвөөс баримт бичигт үзлэг хийн, газар дээрх үнэлгээний багийг томилон ирүүлэхээр тохиролцсон боловч Ковид-19 өвчний халдвар дотоодод гарсан тул хүлээгдэж байна.</p>	50
48		56. Мал, амьтны эмийн санг аттестатчилах;	2020 - 2022		Стандартын дагуу аттестатчилалд хамруулсан байна.	<p>"Мал, амьтны эмийн санд тавих ерөнхий шаардлага MNS 5545:2020" стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумд үйл ажиллагаа явуулж буй малын эмийн сангийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, MNS 5545:2005 стандартын шаардлага хангуулах, зөвлөн туслах чиглэлээр Мал эмнэлгийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг зохион байгууллаа. Стандартын дагуу 2 дугаар зэрэглэлийн эмийн сангийн шаардлага хангасан эсэхэд тулгуурлан шалгалтын ажлыг хийлээ. Шалгалтад 5 эмийн сан хамрагдаж бага эрсдэлтэй үнэлгээ авлаа.</p> <p>Дархан-Уул аймагт малчин өрх, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн түвшинд хэрэглэж байгаа малын эм, бэлдмэлийн тандалт хийсэн. Тандалт судалгаагаар малчин айл өрх, мал эмнэлгийн нэгжүүдэд улсын бүртгэлд бүртгэлгүй эм бэлдмэл гараагүй болно.</p>	70

					Өмнөговь аймаг "МЭМНС-ийн МЭҮН-ийн стандартын үзлэг 2020"-ийг 30 асуултаар үнэлж, цахимд зургийн хамт оруулах удирдамжийг газрын даргаар батлуулж, хяналт шалгалтыг 15 сумын түвшинд зохион байгуулж, 34 мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн эмийн сан, ажлын байрны үзлэг шалгалтыг хийж, тайланг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн мал эмнэлгийн цахим системд тайлагнасан болно.		
49		57. Малын эмийн эм ханган нийлүүлэх байгууллага /импортлогч аж ахуй нэгж/-ыг аттестатчилах;	2020 - 2023		Стандартын дагуу аттестатчилалд хамруулсан байна.	"Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS 6461:2020", "Мал, амьтны эмийн санд тавих ерөнхий шаардлага MNS 5545:2020" стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	70
50	4.2. Мал, амьтны өвчин үүсгэгч нянгуудын мал эмнэлэгт хэрэглэж байгаа антибиотикүүдэд үзүүлэх тэсвэрт чанар болон эмийн гаж нөлөө илрүүлэх, үнэлэх шинжилгээний ажлыг аймаг, нийслэлийн түвшинд зохион байгуулах;	59. Мал эмнэлэгт хэрэглэж байгаа антибиотикүүдэд үзүүлэх тэсвэрт чанар болон эмийн гаж нөлөө илрүүлэх, үнэлэх шинжилгээний ажлыг аймаг, нийслэлийн түвшинд зохион байгуулах;	2020 - 2023		Үнэлгээний хувиар	Мал эмнэлэгт хэрэглэж байгаа антибиотикт үзүүлэх тэсвэрт чанар болон эмийн гаж нөлөө илрүүлэх, үнэлэх шинжилгээний ажлыг аймаг, нийслэлийн түвшинд зохион байгуулах хүрээнд Антибиотикоос сэргийлэх 7 хоногийг салбарын хэмжээнд жил бүр холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. Мөн мал эмнэлгийн зориулалттай малын эм импортлох тусгай зөвшөөрөлтэй Монгол Ви Ти Нет ТББ болон Үндэсний мал эмнэлгийн холбоотой хамтран малын эмч нарын эмийн давтан сургалтад үе шаттайгаар хамруулж байна	70
51	хэрэглэж байгаа антибиотикүүдэд үзүүлэх тэсвэрт чанарыг илрүүлэх, үнэлэх шинжилгээг жил бүр тогтмол хийх;	60. Антибиотикийн хэрэглээг бууруулах зорилгоор эмчлэн сэргийлэх ийлдэс үйлдвэрлэх;	2020 - 2023		Боом, Цусан халдвар, Энтербактериоз, Колибактериоз, Дотрын халдварт хордлогоос сэргийлэх эсрэг ийлдэс үйлдвэрлэсэн байна.	Мал, амьтны халдварт, зооноз өвчнөөс эмчлэн сэргийлэх ийлдсийн үйлдрэлийг 2014 оноос хойш зогсоон, ашиглахыг зогсоон байсан. Гэвч орон нутгийн малын эмч, мэргэжилтнүүд эмчилгээний ийлдсийг дахин ашиглах тухай саналыг удаа дараа тавьж байсан тул Мал эмнэлгийн ерөнхий газрын захиалгаар цусан халдвар, боом, колибактериозын зэрэг 3 нэрийн эмчлэн сэргийлэх ийлдсийг 2020 онд Биокомбинат УТҮГ-т үйлдвэрлэн, орон нутгийн захиалгын дагуу боомын ийлдэс 63, цусан халдварын ийлдэс 67,8, колибактериозын ийлдэс 44 литрийг Мал эмнэлгийн ерөнхий газраас хуваарилсан.	100
52		61. Мал эмнэлгийн эмийн эмчилгээний удирдамжийг боловсруулж батлуулах;	2020		Мал эмнэлгийн эмийн эмчилгээний удирдамжийг батлуулсан байна.	"Нянгийн эсрэг эмийн эмчилгээний удирдамж" боловсруулах зэхэц ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж байна. Үүнд: 1.Нянгийн эсрэг эм, ялангуяа антибиотикыг жороор олгох журам, жор бичилтийн маягт, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтын төслүүдийг хэлэлцүүлээд байна. 2. Антибиотикийн хэрэглээг багасгах зорилгоор "Биокомбинат" -д 4 төрлийн өвчнөөс эмчлэн сэргийлэх ийлдсийг үйлдвэрлэж эхлээд байна. 3. Нянгийн эсрэг эмийн мэдлэг хандлагыг дээшлүүлэх дэлхийн долоо хоногийн	70

					хүрээнд малын эмч, иргэд, малчдыг мэдээллээр хангах зорилгоор TV нэвтрүүлэг, зурагт хуудас, сургалт зохион байгууллаа.		
53	4.3. Мал, амьтны эмийг жороор олгох тогтолцоонд шилжих.	62. Жор бичилтийн загвар маягтыг боловсруулан, батлуулах;	2019		Загвар маягтыг батлуулсан байна.	"Жор бичилтийн загвар, маягт"-ын загварын төслийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгээс "Жор бичилтийн загвар, маягт"-ын загварын төслийг боловсруулж, нэг удаа өргөтгөсөн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэл тогтоосонтой холбоотой хурал хойшлоод байна.	50
54		63. Жор бичилтын стандартыг боловсруулж, батлуулах;	2019		Стандартыг батлуулсан байна.	Жор бичилтын стандартын төслийг боловсруулж, санал авахаар ажиллаж байна. Уг стандартыг 2021 оны 4 дүгээр улиралд СХЗГ-ын хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна.	30
55		64. Эмийн сан, Хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	2020 - 2023		Жор бичилтийг нэвтрүүлсэн хэрэгжилтийн хувиар	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/44 дүгээр тушаалаар ажлын хэсэг томилогдож, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны С/19 дугаар тушаалаар MNS 5545:2020 Мал, амьтны эмийн санд тавих нийтлэг шаардлага” стандартыг батлуулсан.	30
56	4.4. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд эмийн үлдэгдлийг тандах төлөвлөгөөг боловсруулан, батлуулах;	65. Мал болон мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд эмийн үлдэгдлийг тандах төлөвлөгөөг боловсруулан, батлуулах;	2019 - 2023		Төлөвлөгөөг батлуулсан байна.	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг тандалт судалгаа хийх төлөвлөгөөний төслийг боловсруулж, 3 удаа хэлэлцүүлэг хийж, эмийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Эмийн үлдэгдлийг тандах төлөвлөгөө хийх ажлын хэсгийг өргөтгөн батлуулсан.	70
57		66. Мал болон мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд эмийн үлдэгдлийг тандан илрүүлэх шинжилгээний ажлыг Аймаг, нийслэлийн түвшинд жил бүр зохион байгуулах;	2020 - 2023		Нийт 18.0 дээжинд шинжилгээ хийсэн байна.	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан "Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд эмийн үлдэгдэл шинжлэх, тандалт судалгаа хийх" 08 дугаартай удирдамжийн дагуу Улаанбаатар хотын хүнсний захуудад худалдаалагдаж байгаа маханд эмийн үлдэгдлийг тандан илрүүлэх ажлыг зохион байгуулсан. Хүнсний захуудаас бэлтгэсэн нийт 150 сорьцод эмийн үлдэгдлийн тандалт судалгаа хийсэн. Тандалтын дүнгээр: Тетрациклин, хлорамфениколын бүлгийн антибиотик, албендазол, мебендазол, тиабендазол зэрэг эндопаразитын эсрэг шинжилгээ хийхэд: • Нийт сорьцын 2% /3 сорьц/-д хлортетрациклин 0,1-0,68 мкг/кг -ийн хооронд (зөвшөөрөгдсөн дээд хэмжээ 200 мг/мкг) • 4% /6 сорьц/-д хлорамфениколын үлдэгдэл 0,08-0,1 мкг/кг хооронд (зөвшөөрөгдсөн дээд хэмжээ 100 мг/мкг) илэрсэн. Дээрх шинжилгээний дүн нь олон улсын зөвшөөрөгдөх хэмжээтэй харьцуулахад маш бага байгаа бөгөөд тандалтад хамруулсан нийт сорьцод тетрациклин, хлорамфенолын бүлгийн антибиотик, албендазол, тиабендазолын үлдэгдэл илрээгүй.	70

58		67. Мал болон мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд эмийн үлдэгдлийг тандан илрүүлэх шинжилгээний ажлыг мах, сүү боловсруулах үйлдвэр, цехийн түвшинд жил бүр зохион байгуулах;	2020 - 2023			МЭЕГ-ын даргын баталсан "Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд эмийн үлдэгдэл шинжлэх, тандалт судалгаа хийх" 08 дугаартай удирдамжийн дагуу Улаанбаатар хотын хүнсний захуудад худалдаалагдаж байгаа маханд эмийн үлдэгдлийг тандан илрүүлэх ажлыг зохион байгуулсан. Махнаас түүврийн аргаар цуглуулсан нийт 150 сорьцод эмийн үлдэгдлийн тандалт судалгаа хийсэн. Тандалтын дүнгээр: Тетрациклин, хлорамфениколын бүлгийн антибиотик, албендазол, мебендазол, тиабендазол зэрэг эндопаразитын эсрэг шинжилгээ хийхэд: • Нийт сорьцын 2% буюу 3 сорьцод хлортетрациклин 0,1-0,68 мкг/кг -ийн хооронд (зөвшөөрөгдсөн дээд хэмжээ 200 мг/мкг) • 4%-д буюу 6 сорьцод хлорамфениколын үлдэгдэл 0,08-0,1 мкг/кг хооронд (зөвшөөрөгдсөн дээд хэмжээ 100 мг/мкг) илэрсэн. Дээрх шинжилгээний дүн нь олон улсын зөвшөөрөгдөх хэмжээтэй харьцуулахад маш бага байгаа бөгөөд тандалтад хамрагдсан нийт сорьцод тетрациклин, хлорамфенолын бүлгийн антибиотик, албендазол, тиабендазолын үлдэгдэл илрээгүй.	70
ЗОРИЛТ 4							62.14
59	5.1. Мал эмнэлгийн эмийн бүртгэл, эмийн чанарын баталгаажуулалт, эм хангамжийн байгууллагын нэгдсэн цахим бүртгэлийн тогтолцоог хөгжүүлэх;	68. Нэгдсэн цахим бүртгэлийн санг бий болгох;	2019 - 2020		Нэгдсэн цахим бүртгэлийн сантай болсон байна.	“Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн цахим сан”-гийн хөгжүүлэлтийг Ооллинк компани гүйцэтгэж байна. Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори нь “Стандарт хэмжилзүйн газар”-ын даргын 2020 оны А/150 дугаар тушаалаар MNS ISO/EIC 17065:2013 стандартаар итгэмжлэгдэн Монгол улсад малын эмийн чанарын баталгаажуулалтыг гүйцэтгэж байна. Малын эм, биобэлдмэл, тэжээлийн нэмэлт, эмийн түүхий эдийн сорилт баталгаажуулалтын үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн цахим “DLIMS” системд шилжүүлсэнтэй холбогдуулан dlms.shinjlgee.mn цахим хуудас ашиглан сорилт баталгаажуулалтад хамрагдаж байгаа сорьцыг хүлээн авч, лабораторийн нэгдсэн санд бүртгэж, сорилтын лабораторид сорьц хүлээлгэн өгөх, хуваарилах, баталгаажуулалтын дүгнэлт гаргах, эмийн архив бүрдүүлэх, тайлан гаргах, сорилт, баталгаажуулалтын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх, хэрэглэгчдэд шуурхай үйлчлэх бүрэн боломжтой болсон байна.	100
60		69. Нэгдсэн цахим бүртгэлийн санд оруулах мэдээллийг бэлтгэх;	2019 - 2021		Мэдээллийг бэлтгэсэн байна.	Мал эмнэлгийн зориулалттай малын эм, тэжээлийн нэмэлт импортлох тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл, малын эмийн улсын бүртгэл, Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторийн шинжилгээний дүгнэлт, малын эмийн хэрэглэх заавар, малын эмийн эрхзүйн мэдээлэл бүхий цахим сангийн хөгжүүлэлт хийгдэж байна.	100

61	5.1. Мал эмнэлгийн эмийн бүртгэл, эмийн чанарын баталгаажуулалт, эм хангамжийн байгууллагын нэгдсэн цахим бүртгэлийн тогтолцоог хөгжүүлэх;	70. Аймаг, нийслэл, сумын түвшинд нэгдсэн цахим бүртгэлийн санг нэвтрүүлэх;	2019 - 2022	Цахим бүртгэлийн санг нэвтрүүлсэн байна.	"Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн цахим сан"-гийн хөгжүүлэлтийг Ооллинк компани хийж байна.	70
ЗОРИЛТ 5						90.00
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ						72.02